Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 16-ны өдрийн
А/247 дугаар захирамжийн
хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

[√] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

[ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Өвөрхангай аймгийн Насан туршийн боловсролын төв | |

| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
|---|---|
| Насан туршийн боловсрол төвийн дарга | Төрийн үйлчилгээ, ТҮБД-5 |

| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
|---|---|
| Ажлын өдөр 8 цаг | Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13 дугаар баг, Хүүхдийн ордон. |

| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
|---|---|
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, насан туршийн боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, удирдлагыг мэдээллээр хангах чиг үүргийг

| |
|---|
| хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцна. |
| Албан тушаалын зорилт:<br>1. Боловсролын салбарын хууль тогтоомж, насан туршийн боловсролын талаар баримтлах чиглэл, аймгийн бодлого стратегийн хэрэгжилтийг хангуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих, тайлагнах.<br>2. Насан туршийн боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах.<br>3. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх. |

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр<br>Туслах - Т,<br>Хариуцан гүйцэтгэх - Г<br>Хянах – Х<br>Шийдвэрлэх – Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Боловсролын тухай хууль болон салбарын хүрээнд хэрэгжиж буй бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх; | Хууль тогтоомжийн хэрэгжилтээр | Г, Х, Ш |
| | 2. Монгол Улсын хөгжлийн бодлого, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, улс, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хамааралтай зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, тайлагнах; | Хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилтээр | Г,Х,Ш |
| | 3. Засгийн газар, аймгаас батлан гаргасан бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах; | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтээр | Г,Х,Ш |
| | 4. Боловсролын салбарт хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлт үр дүнг тайлагнах. | Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгээр | Г,Х,Ш |
| 2 дугаар зорилт | 1. Иргэдийн боловсролын түвшин, сургалтын хэрэгцээнд судалгаа | Асуудлыг тусган хэрэгжүүлсэн байна. | Г.Х |

| | | | |
|---|---|---|---|
| ын хүрээнд | шинжилгээ хийж, санал дүгнэлт боловсруулах, бодлого, шийдвэрт тусган хэрэгжүүлэх;<br>2. Сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг төрийн ба төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;<br>3. Насан туршдаа суралцахуй сургалтыг зохион байгуулж, үр дүнг тайлагнах;<br>4. Насан туршийн боловсролын нэгжийн багш нарыг мэргэжлийн удирдлагаар хангах;<br>5. Сургалтын орчин бүрдүүлэх, тоног төхөөрөмжийг ашиглах, сурах бичиг гарын авлагыг нэмэгдүүлэх, ашиглалтад хяналт тавих, тайлагнах. | Иргэдийн боловсролыг тасралтгүй хөгжүүлнэ.<br>Сургалт нөлөөллийн ажил хийгдсэн байна.<br>Мэдлэг чадвар дээшилсэн байна.<br>Сургалтын орчин бүрдсэн байна. | Г. Х<br>Г,Х,Ш<br>Г,Х,Ш<br>Г, Ш |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1. Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх, төвийн тухайн жилийн төсөв, цалингийн санг зохих журмын дагуу зарцуулах, тайлагнах;<br>2. Байгууллагын санхүүгийн дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх, биет хөрөнгийн нөөцийг төлөвлөх, ашиглалтыг сайжруулах, төсвийн болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулж, хяналт тавьж ажиллах;<br>3. Байгууллагын болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах;<br>4. Төрийн албаны тухай хууль, ёс зүй, сахилга хариуцлагатай холбогдох дүрэм, журмыг чанд мөрдөн ажиллаж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах;<br>5. Чиг үүргийн хүрээнд тайлагнах бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэр, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ | Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлсэн байна.<br>Төсөв, санхүүгийн зөрчилгүй ажилласан байна.<br>Төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгээр<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.<br>Хэрэгжилт, үр дүнгээр<br>Өргөдөл, гомдол шийдвэрлүүлсэн байдлаар, | Г,Х,Ш<br>Г,Х,Ш<br>Г,Х<br>Г<br>Г |

| | | | |
|---|---|---|---|
| | хийх, тайлагнах;<br>6. Албан бичиг болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хэрэгжилтийг хангаж ажиллах;<br>7. Файлын эмх цэгцийг сайжруулах, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримтыг эмхлэн цэгцэлж, бүрэн бүрдэлтэй нь байгууллагын архивт хүлээлгэн өгөх;<br>8. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл, үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцан ажиллах. | Байгууллагын архивт хүлээлгэн өгсөн баримтын тоогоор<br>Үүрэг даалгаврын биелэлтээр | Г,Х<br>Г, Х<br>Г |

| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | | |
|---|---|---|
| Боловсрол | Боловсролын бакалавр түүнээс дээш боловсролын зэрэгтэй | |
| Мэргэжил | Багш | |
| Мэргэшил | Боловсрол, нийгэм, төрийн удирдлага | |
| Туршлага | - Боловсролын салбарт 5 болон түүнээс дээш жил ажилласан байх<br>- Мэргэжлийн зэрэгтэй байх | |
| Ур чадвар | Удирдан зохион байгуулах | - хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах;<br>- албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилж, удирдан зохион байгуулах;<br>- албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, өдөр тутмын удирдлагаар хангах;<br>- хариуцсан нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж, шаардлага тавьж чаддаг байх;<br>- бусад. |
| | Дүн шинжилгээ хийх | - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах;<br>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;<br>- судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх;<br>- тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх, статистикийн арга хэрэгслийг ашиглах чадвартай байх;<br>- бусад. |
| | | - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард |

| | | |
|---|---|---|
| | Асуудал шийдвэрлэх | түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;<br>- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;<br>- шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх;<br>- аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;<br>- албан үүргээ ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид шийдвэрлэх;<br>- хууль, эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;<br>- бүтээлч, санаачилгатай ажиллах;<br>- бусад. |
| | Манлайлах | - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;<br>- багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;<br>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;<br>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;<br>- хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх;<br>- нээлттэй шударга байх;<br>- бусад. |
| | Бусад | - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;<br>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;<br>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх. |

## IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

<u>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u>

Өвөрхангай аймгийн Засаг дарга

| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект : |
|---|---|
| - Сургалтын менежер<br>- Нийгмийн ажилтан<br>- Багш<br>- Гэрээт нягтлан бодогч | - Насан туршийн боловсролын үндэсний төв,<br>- Аймгийн Засаг даргын орлогч,<br>- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд,<br>- Аймгийн Засаг даргын дэргэдэх, хэлтэс, агентлагын дарга, мэргэжилтнүүд,<br>- Сумдын Засаг дарга, түүний Тамгын газрын дарга, мэргэжилтнүүд,<br>- Сумдын насан туршийн боловсролын нэгжийн багш, арга зүйч,<br>- Иргэд олон нийт. |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<table>
<tr><td><u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u></td><td><u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u></td></tr>
<tr><td><u>Албан тушаал</u>:<br>АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА<br>.....................................Б.САЙНЖАРГАЛ<br>20 22 оны .05.. дугаар сарын 16...-ны өдөр</td><td><u>Байгууллагын нэр:</u><br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br><u>Шийдвэрийн огноо:</u> ...............<br><br><u>Дугаар</u>: ...............</td></tr>
<tr><td colspan="2">АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:</td></tr>
<tr><td colspan="2"><u>Байгууллагын нэр</u><br>АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР<br>Шийдвэрийн огноо: 2022.05.16.<br>Дугаар: А/247<br><br>(тамга/тэмдэг)<br><br>АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ...................................................../А.ИШДОРЖ/<br>2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр</td></tr>
</table>

-oOo-

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 16 өдөр Дугаар А/247 Арвайхээр

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Насан туршийн боловсролын төвийн даргын албан тушаалын тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан албан тушаалын тодорхойлолтын зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр мэргэшил, арга зүйгээр хангаж, ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Сайнжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ

6222 11 0527

D:My Doc. Zahiramj. Zasag darga